

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН
ТОМЬЁОЛОЛ**

Нэг.Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжсэн санал:

1.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтын “бусад” гэсний дараа “гадаад орчин дахь” гэж нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн
Л.Эрдэнэчимэг**

2.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалтын “цэгийг” гэсний дараа “300 м²-аас доошгүй талбай бүхий барилга, байгууламжид нэгээс илүүгүй байхаар” гэж нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн
Л.Эрдэнэчимэг**

3.Хуулийн төслийн “6 дугаар зүйл:6.Үйлдвэрлэх гэдгийн ард “худалдахад, хэрэглэхэд” гэж нэмэх” гэснийг “6 дугаар зүйлийн гарчгийн “худалдахад” гэснийг “худалдах, хэрэглэхэд” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн
Д.Батцогт**

4.Хуулийн төслийн “6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг 6.4.“Тамхи нь” гэдгийн өмнө “Зөвшөөрөгдсөн цэгт анхааруулах тэмдэг байрлуулах бөгөөд” гэж нэмэх” гэснийг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн
Д.Батцогт**

**Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх
ухааны байнгын хороо**